

ШАЛГАЛТ ЯМАР БАЙДАГ, ТА ЮУ ЧАДАХ ЁСТОЙ ВЭ

УНШИХ: Та асуулга маягт дээрх мэдээлэл, гудамж, тээврийн хэрэгсэл болоод ажлын газарт байгаа бичээс тэмдэглэлийг ойлгох ёстой. Та цахим хуудас болон цахим дэлгүүрийн зар сурталчилгааг ойлгох ёстой. Та дэлгүүр, эмч, эмнэлэгт байгаа үндсэн хаяг бичээсийг ойлгох ёстой. Та энгийн захиа эсвэл смс зурвасыг ойлгох ёстой. Та энгийн зааврыг (жишээлбэл: зогсоолын төлбөрийг хэрхэн төлөх гэх мэт) ойлгох ёстой.

БИЧИХ: Та цахим дэлгүүрт бараа захиалах зэрэг интернетийн төрөл бүрийн маягт, хүснэгтийг бөглөх чадвартай байх ёстой. Та амралт, аялал зугаалгаас мэндчилгээ бичиж чаддаг байх ёстой. Та төрсөн өдөр, хурим, айлчлал зэрэг арга хэмжээнд чех найз нараа урих чадвартай байх ёстой. Та ажил төдийгүй сургууль руу уучлалт гуйсан зурвас бичиж чаддаг байх ёстой. Та чөлөө эсвэл амралтаа авахыг хүсэж буйгаа илэрхийлэх чадвартай байх ёстой. Та энгийн зар сурталчилгаа бичих, зар сурталчилгаанд хариу өгч чаддаг байх ёстой. Та чех цагаан толгойн бүх үсгийг бичихээс гадна цэг, асуултын тэмдэг, анхаарлын тэмдгийг бичиж чаддаг байх ёстой.

СОНСОХ: Та галт тэрэгний буудал, дэлгүүрийн зарлан мэдээллийг ойлгох ёстой. Та радио, телевиз, интернетийн видеон дээрх гол мэдээллийг ойлгох ёстой. Та утсан дээрх үндсэн мэдээллийг ойлгох ёстой. Та бүх дугаар, нэрийг үсгийн дуудлагаар бичиж чаддаг байх ёстой. Та дэлгүүр, үйлчилгээ (үсчин, хувцас цэвэрлэгээний газар гэх мэт), эмч эсвэл эмнэлэгт өгч буй үндсэн мэдээллийг ойлгох ёстой. Та найзынхаа гэр бүл, ажил, чөлөөт цагийн тухай ярьж байгааг ойлгох ёстой. Ажил дээр танай дарга танд ямар нэгэн энгийн даалгавар эсвэл ажил хэрхэн хийхийг тайлбарлавал ойлгох ёстой.

ЯРИА: Та дэлгүүрээс мэдээлэл авч, янз бүрийн үйлчилгээг захиалж чаддаг байх ёстой. Та ажил дээрээ хамт ажиллагсадтайгаа ярьж тохирох чадвартай байх ёстой. Та ямар нэгэн зүйл, үйлчилгээ эсвэл мэдээлэл асуун сураглаж, түүндээ талархах, янз бүрийн нөхцөл байдалд уучлалт гүйх, хэн нэгнийг арга хэмжээнд урих, зөвлөгөө авч чаддаг байх ёстой. Та амьдрал, гэр бүл, ажлынхаа талаар хэдэн өгүүлбэр хэлэх чадвартай байх ёстой. Танд юу таалагддаг, таалагддаггүй болон юунд дуртайгаа хэлж чаддаг байх ёстой. Танд тохиолдсон зүйл эсвэл юу харснаа хэлж чаддаг байх ёстой. Та хоол хүнс, дэлгүүр хэсэх, эрүүл мэнд, чөлөөт цаг гэх мэт янз бүрийн зүйлийн талаар дор хаяж 1 минут ярих чадвартай байх ёстой.

ҮГИЙН БАЯЛАГ: Та шалгалтын бүх хэсэгт (унших, бичих, сонсох, ярих) ойлголцож, харилцахын тулд үндсэн бүх үгсийг мэддэг байх ёстой. Гэхдээ та бас мэдэхгүй үгээ асууж чаддаг байх ёстой. Та ийм үгийг бичиж чаддаг байх ёстой. Энэ үгийг хэрхэн, хаана хэрэглэдгийг та асууж чаддаг байх ёстой.

ДҮРЭМ: Та жинхэнэ нэр (substantiv), тэмдэг нэр (adjectiv), төлөөний үгийн ганц тоо (singulár)-ны үндсэн хэлбэрийг мэддэг байх ёстой. Та олон тооны (plurál) үндсэн хэлбэрийг таньдаг байх ёстой. Та одоо, ирээдүй, өнгөрсөн цагийг чаддаг байх ёстой.

ДУУДЛАГА: Шалгалтын үеэр бид таныг ойлгох ёстой тул та цэвэр зөв дуудлагаар ярьж чаддаг байх ёстой. Та хэт хурдан эсвэл удаан ярьж болохгүй.

Шалгалт ямар байдгийг мэддэг байх хэрэгтэй (шалгалтын хэлбэр): Шалгалтын явцад хэрхэн хариулах, юу хийхээ мэдэхийн тулд шалгалтын загвар (өөрийгөө турших шалгалт)-тай танилцах ёстой. Та шалгалтад бэлдэх хэрэгтэй.